



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/288

Номгон

Г
Цэргийн дүйцүүлэх албаны "Бэлтгэл шатны"
сургалт явуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам", Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 241 дүгээр тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах" журмын 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын "Бэлтгэл шатны" сургалтыг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэл 7 хоногийн хугацаатай зохион байгуулсугай.

2.Сургалтын хугацаанд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдаар орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулж хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т даалгасугай.

3.Сургалтад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

4.Сургалтын зардалд шаардагдах 9,396,100 (Есөн сая гурван зуун ерэн зургаан мянга нэг зуу) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д үүрэг болгосугай.



626010799